



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАТЛАВ.

ГХУХ-ын ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ
/Албан тушаал/



Г.АРИУНБУЯН
/Гарын үсгийн тайлал/

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УДИРДАМЖ

2026 оны 06 дугаар сарын 05

Дугаар 02

Улаанбаатар хот

Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх
бэлэн байдлыг хангуулах

Нэг. Удирдамжийн зорилго

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйл “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах”, 10.3.3. Улсын онцгой комиссын даргын 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар албан даалгавар, Монгол Улсын Шадар сайдын “Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний хэрэгжилтийг хангуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үер, усны аюулын үед ажиллах бэлэн байдлыг хангуулах, үерийн ус зайлуулах инженерийн барилга байгууламжид хяналт шалгалт хийж бэлэн байдлыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

2.1. Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж сар бүрийн 25-ны өдөр хийсэн ажлын тайланг гаргаж ирүүлэх.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагатай хамтран Онцгой байдлын газар, хэлтсийн эрх бүхий албан тушаалтан нар үерийн ус зайлуулах инженерийн барилга байгууламжид үзлэг, хяналт шалгалт хийнэ.

2.3 Төв, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, иргэн, хуулийн этгээд хамрагдана.

Гурав. Хяналт шалгалтын төрөл, арга хэмжээ, чиглэл

3.1.Төрийн болон аж нэгж байгууллагуудад хэрэгжүүлсэн байх арга хэмжээ;

3.1.1. Улсын Онцгой комиссын 03 дугаар албан даалгаврыг аймаг нийслэл сум дүүргийн Онцгой комисс хэрэгжилтийг хангуулж байгаа эсэх.

3.1.2 Үер, усны аюул үүссэн үед Онцгой байдлын байгууллага болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас дайчлан ажиллуулах хүн хүч, техник, багаж хэрэгслийн

1426270002

судалгааг бодит байдлаар гаргах, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, бэлтгэл, бэлэн байдалд хяналт шалгалт зохион байгуулах;

3.1.3 Үерийн дараах болзошгүй хор уршгаас үүдэлтэй халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулах ажлын бэлэн байдал;

3.1.4 Үерийн үед ажиллах хүч хэрэгсэл, техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, нөөцийг бүрдүүлэх, шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлүүлсэн эсэх;

3.1.5 Ус цаг уур, орчны шинжилгээний газраас цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан тодруулж, үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг иргэд, малчид, аж ахуйн нэгж байгууллагад хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэх ажлын хэрэгжилтэд тогтмол хяналт хийх;

3.2. Үерийн хамгаалалтын байгууламж дэд бүтцийн бэлэн байдлыг хангуулах чиглэлээр

3.2.1 Төв, орон нутгийн хэмжээнд үерийн эрсдэл бүхий голын эрэг, далан, суваг, шуудуунд үерийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд шаардлагатай тусгай зориулалтын автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулсан эсэх. (хиймэл далан, гүүр, ус шингээх шуудай, элс, шуудай);

3.2.2 Үерийн эрсдэл бүхий орон сууцны зоорийн давхаруудад үерийн ус, хөрсний ус орохоос урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж хариуцсан хуулийн этгээдэд (Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, Сууц өмчлөгчдийн холбоо) эрх зүйн баримт бичгийг хүргүүлж биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.2.3 Үер, усны аюулын эрсдэлийг үнэлэх, үерийн хамгаалалт, ус зайлуулах зориулалтын инженерийн барилга байгууламжид үзлэг, шалгалт зохион байгуулж, далан, суваг, шуудууны цэвэрлэгээг хариуцагч байгууллагаар хийлгэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийх;

3.2.4 Үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний ус зайлуулах шугамын ашиглалтын хэвийн найдвартай ажиллагааг хангаж, лаг шавар, хог хаягдлыг цэвэрлэсэн эсэхэд хяналт тавьж холбогдох мэргэжлийн байгууллагад шаардлага хүргүүлэх;

3.3. Иргэд олон нийтийг усны осол үерийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар;

3.3.1 Иргэдийн амарч зугаалдаг гол мөрөн нуурын эрэг орчим усны осолд бага насны хүүхэд, иргэн өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ орон нутгийн Онцгой комиссоос зохион байгуулж байгаа эсэх;

3.3.2 Ахуйн зориулалттай шаардлага хангахгүй хийлдэг завь, гудас, хөвөгчийг гол, нуурын усанд ашиглахгүй байх талаар мэдээ мэдээлэл бэлтгэн иргэд олон нийтэд анхааруулга санамжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд түгээх ажлын хэрэгжилт;

3.3.3 Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, амрылтын газар, жуулчны баазууд үер усны гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажил төлөвлөж хэрэгжүүлж байгаа эсэх;

3.3.4 Орон нутгийн хэмжээнд иргэд олон нийтэд усны осол, үер усны гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж байгаа эсэх;

3.4.5 Усны урсац, голын голдирол бүхий газруудад хяналт шалгалт хийж тухайн газар оронд суурьшсан иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган эрх бүхий албан тушаалтны эрх зүйн баримт бичгийг хүргүүлж биелэлтэд хяналт тавьж ажиллах;

Дөрөв. Хяналт шалгалтын үр дүн, зардал

4.1. Удирдамжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын Шадар сайдын 2026 оны “Үер, усны ослын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний” удирдамжинд заасны дагуу мөн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны зардлаас шийдвэрлүүлэх.

4.2. Төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан хяналт шалгалтын арга хэмжээний мэдээ, тайлан, үр дүнг сар бүрийн 25-ны өдрийн дотор нэгдсэн тайланг 2026 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газартцахим хаягаар баталгаажсан тайлан (файлаар, зурган тайлан) ирүүлнэ.

---oOo---